

“СЭНЖ САНТ”- ТӨСӨЛ (ЗЭЭЛ)

Улс:	Монгол
Төслийн дугаар:	43044
Бизнесийн салбар:	Үйлдвэр, үйлчилгээ
Төрийн/Хувийн:	Хувийн
Байгаль ончны ангилал:	А
Захирлуудын зөвлөлийн огноо:	2012 оны 11-р сарын 27
Статус:	Бүтцийн хэлэлцүүлэг давсан , Эцсийн Хэлэлцүүлэг хүлээгдэж байгаа
Төслийн хураангуй нийтлэгдсэн огноо:	2012 оны 10-р сарын 12

Төслийн танилцуулга

ЕСБХБ нь Улаанбаатар хотоос 450 км-ийн зайд байрлах Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт хуурай технологитой, өдөрт 1500 тонн цемент боловсруулах үйлдвэрийг барьж, ашиглалтанд оруулах төслийг санхүүжүүлэх асуудлыг судлаж байна.

Шилжилтийн үйл явцад үзүүлэх нөлөөлөл

Энэхүү төсөл нь Монголын аж үйлдвэрийн салбар дахь томоохон хэмжээний төсөл болох юм. Түүнчлэн Монголын цементийн секторт анхны байгалд ээлтэй хуурай технологи бүхий үйлдвэр болох бөгөөд гадаадын нэр хүндтэй Лафарж компани тус үйлдвэрийн техникийн шийдэл дээр ажиллах юм. Мөн энэ төсөл нь хувийн хэвшлийг хөгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа болохоос гадна импортоос хараат, дотоод үйлдвэрлэл харьцангуй хөгжиж чадаагүй байгаа энэ салбарыг бас хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулна.

Төслийг хэрэгжүүлэгч байгууллага нь уул уурхайгаас бусад салбарт төрөлжсөн дотоодын аж ахуйн нэгж тул ашигт малтмалаас хараат Монголын эдийн засгийн төрөлжүүлэхэд дэмжлэг болно.

Төсөл нь дараахь байдлаар шилжилтийн үйл явцад нөлөө үзүүлнэ. Үүнд:

(i) Төрөлжсөн чадварыг суралцаж эзэмших: Лафарж шиг олон улсын томоохон компанитай хамтран ажилласнаар бусад компани, төслүүдэд олон улсаас туршлагаас хуваалцах, таниулах, түгээх боломж олгоно. Техникийн тусламж, O&M гэрээний хүрээнд тусгагдах техникийн болон менежерийн сургалтын хөтөлбөрүүдээр дамжуулж дотоодын ажилчдын мэдлэг, чадварыг сайжруулна.

(ii) Эрчим хүчний хэмнэлт, байгаль орчны стандартыг нэвтрүүлэх: Хуурай технологитой цементийн үйлдвэр анх удаа барих төсөлд хөрөнгө оруулж буй нь шинэ технологи, стандартыг зах зээлд нэвтрүүлж байгаа явдал юм. Баригдах үйлдвэр нь тоос,

NOx, SOx болон бусад бохирдуулагчийн талаарх ЕХ-ны Цементийн үйлдвэрийн ВАТ мөн ЕСБХБ-ны БОЭМАА-ны стандартууд мөрдөж ажиллах болно.

Харилцагч

Сэнж Сант ХХК нь барилга, барилгын материалын үйлдвэрлэл, эрүүл хүнсний худалдааны салбарт олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг, алт олборлолтын тэргүүлэх компани болох Монполимет ХХК-ий бүрэн эзэмшлийн салбар компани юм. Лафарж Эс-Эй нь дэлхийн цементийн үйлдвэрлэлийн тэргүүлэгч ба улс орнуудад стратегийн түншлэгч хэлбэрээр зах зээлээ тэлж буй компани юм.

ЕСБХБ-ны санхүүжилт

20% хүртлэх хөрөнгө оруулалтын зээл мөн арилжааны банк ба/эсвэл олон улсын хөгжлийн хөрөнгө оруулагч байгууллагуудтай хамтран 110 сая ам.доллар хүртлэх зээл олгоно.

Төслийн өртөг

Ойролцоогоор 185 сая ам.доллар

Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл

Тус төслийг Банкны 2008 оны Байгаль орчин болон Нийгмийн бодлогын хүрээнд “А” түвшний ангилалд багтаасан.

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) нь Монгол улсын стандартын дагуу бэлтгэгдсэн. Мөн Монголын энэ бүс нутгийн усны хэрэглээ нь эмзэг асуудал тул гүний усны ашиглалттай холбоотой байгаль орчин, нийгмийн нөлөө болон гидрологийн нэмэлт мэдээлэл бүхий Байгаль орчин, нийгмийн тайлан давхар гаргах болно.

Банкны Байгаль орчин, нийгмийн зохих мөрдлөгийн шалгалтаар уг компани нь банкны үйл ажиллагааны шаардлагыг (ҮАШ) хангах чадавхитай бол төсөл нь банкны ҮАШ, Монголын болон ЕХ-ны байгаль орчны стандартыг мөрдөж чадах бүтэцтэй гэдэг нь нотлогдсон. Үйлдвэрийг ЕХ-ны Хамгийн сайн боломжтой техникийн (ХСБТ) дагуу барьж, ажиллуулах ба үүнд байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны менежментийн систем болон хүлэмжийн хийг байнга хянах системийн суурьлуулалт байгтаж байгаа юм. Гүний усны ашиглалтыг үнэлж, улмаар боломжит нөлөөл, ялангуяа байгалийн булаг шанданд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээг нэмж тусгасан. Уг компани нь төслийн бүх шатанд гүний усанд мониторинг тавих хөтөлбөр хэрэгжүүлэх ба үйлдвэртийн өргөтгөл хийхээс өмнө (Үе шат II) нэмэлт гүний усны эх үүсвэрийн судалгаа хийнэ. Энэ төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг эндээс унших боломжтой.

Техникийн хамтын ажиллагаа

Байхгүй

Компанитай холбоо барих

Ноён Чойжил Дэлгэрэхбулаг
Сэнж Сант ХХК-ны Захирал
Дамдинсүрэнгийн Гудамж-1
Сүхбаатар дүүрэг-1
Улаанбаатар
Монгол улс

Утас: (976)-11-311633
Факс: (976)-11-311633
И-мэйл: degi@monpolymet.mn
URL: www.monpolymet.com

Бизнесийн боломжууд

Бизнесийн боломжууд болон худалдан авалтын талаарх асуудлаар Харилцагч компанитай холбоо барина уу.

Ерөнхий лавлагаа авах

Ерөнхий лавлагаа:
Утас: +44 20 7338 7168; Fax: +44 20 7338 7380
И-мэйл: projectenquiries@ebrd.com

Олон нийтэд мэдээлэх журам (ОНМЖ)

ОНМЖ-д ЕСБХБ-ны баримталж буй стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаар нийтэд мэдээлэл, ойлголт өгөх зорилгоор мэдээллийг хамааралтай этгээдэд хэрхэн хүргэх болон тэдэнтэй зөвлөх журмыг тодорхойлсон.

[ОНМЖ](#)

Төслийн талаарх санал гомдлын механизм (ТТСГМ)

ЕСБХБ нь хувь хүн эсхүл байгууллагад Банкнаас санхүүжүүлж буй төсөл сөргөөр нөлөөлж буй тохиолдолд тэдэнд хараат бус байдлаар санал гомдол тавих боломж олгох үүднээс Төслийн талаарх Санал гомдлын механизм (ТТСГМ)-ыг бий болгосон. ТТСГМ-ыг зохицуулах журмыг

дараах холбоосноос үзнэ үү: www.ebrd.com/downloads/integrity/pcmrules.pdf, мөн Орос хувилбарыг үзэх бол: <http://www.ebrd.com/downloads/integrity/pcmrulesr.pdf>-ээс орж үзнэ үү.

ЕСБХБ-аас санхүүжилт олгосноос 12 сарын дотор ТТСГМ-ын дагуу аливаа санал гомдлыг илгээнэ үү. Санал гомдол мэдүүлэх хугацаа тодорхой бус бол энэ талаар ТТСГМ-ыг хариуцсан ажилтан (pcm@ebrd.com гэсэн хаягаар) эсхүл ЕСБХБ-ны төлөөлөгчийн газартай холбогдож мэдээлэл авна уу.

Энэхүү төслийн товч танилцуулгын материалуудыг ЕСБХБ-ны Захирлуудын зөвлөл тус төслийг авч хэлэлцэхээс өмнө гаргасан болно. Төслийн дэлгэрэнгүй мэдээллүүд нь Төслийн хураангуйг гаргасны дараа өөрчлөгдсөн байж болох бөгөөд энэ нь ЕСБХБ-ны албан ёсны бодлогыг төлөөлөх баримт бичигт тооцогдохгүй болно.